

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Цагаан эрэг тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/011/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас:7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayrts@audit.gov.mn">Otgonbayrts@audit.gov.mn</a> Аудитор: Р.Отгонжаргал Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Otgonjargalr@audit.gov.mn">Otgonjargalr@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	8
3.5 Зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
4. Аудитын тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. Аудитын илрүүлэлт	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	15

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**“ЦАГААН ЭРЭГ ТОХИЖИЛТ  
ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Д.ЦЭЛМЭГ ТАНАА**

2026.03.12 № ДТ-2026/011/НА-СТА-ОНӨАТ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь тайлант онд Сүхбаатар сумын хөрөнгө оруулалтаар 82,600.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 34,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 17,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 1,541,155.4 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн зам талбай, 82,175.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 36,368 мянган төгрөгийн газар зэргийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахлаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч борлуулалтын орлого, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

“Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2025 оны үйл ажиллагааны явцын тайланг хэлэлцээд Сүхбаатар сумын ИТХ-ын 2025 оны 05 дугаар хуралдаанаар “*хангалттай сайн*” гэж үнэлүүлсэн байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,019,918.42	1,831,563.73
1.1.2.	Дансны авлага	20,061,573.05	9,947,713.37
1.1.5.	Дуусаагүй үйлдвэрлэл	28,850,000.00	28,850,000.00
1.1.6.	Бараа материал	51,944,353.00	117,346,253.00
<b>1.1.10.</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн нийт дүн</b>	<b>101,875,844.47</b>	<b>157,975,530.10</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1.	Үндсэн хөрөнгө	2,560,556,279.11	3,457,180,226.86
1.2.2.	Биет бус хөрөнгө	205,162.19	-
<b>1.2.9.</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн</b>	<b>2,560,761,441.30</b>	<b>3,457,180,226.86</b>
<b>1.3</b>	<b>Хөрөнгийн нийт дүн</b>	<b>2,662,637,285.77</b>	<b>3,615,155,756.96</b>
<b>2.</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	-	-
<b>2.1.1.</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	-
2.1.1.1.	Дансны өглөг	14,098,608.75	6,390,045.51
2.1.1.3.	Татварын өр	15,941,464.62	576,167.42
2.1.1.4.	НДШ-ийн өглөг	12,949,380.45	-
<b>2.1.1.12.</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн</b>	<b>42,989,453.82</b>	<b>6,966,212.93</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>42,989,453.826</b>	<b>6,966,212.93</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	-	-
2.3.8.	Эздийн өмчийн бусад хэсэг	5,057,991,378.39	6,192,773,761.39
2.3.9.	Хуримтлагдсан ашиг	-2,438,343,546.44	-2,584,584,217.36
2.3.10.	Эздийн өмчийн нийт дүн	2,619,647,831.95	3,608,189,544.03
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН</b>	<b>2,662,637,285.77</b>	<b>3,615,155,756.96</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1.	Татаас санхүүжилтийн орлого	1,100,000,000.00	1,773,103,800.00
2.	Борлуулалтын өртөг	-	-
<b>3.</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>1,100,000,000.00</b>	<b>1,773,103,800.00</b>
8.	Бусад орлого	3,134,993.59	-
9.	Борлуулалт, маркетингийн зардал	500,000.00	-
10.	Ерөнхий ба удирдлагын зардал	1,598,393,086.75	1,921,136,395.92
17.	Бусад ашиг (алдагдал)	18,544,658.00	3,974,000.00
<b>18.</b>	<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-477,213,435.16</b>	<b>(144,058,595.92)</b>
19.	Орлогын татварын зардал	-	-
<b>20.</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-477,213,435.16</b>	<b>(144,058,595.92)</b>
<b>22.</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-477,213,435.16</b>	<b>(144,058,595.92)</b>
<b>23.</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	2,182,075.00
23.1.	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2.	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3.	Бусад олз (гарз)	-	-
<b>24.</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>-477,213,435.16</b>	<b>(141,876,520.92)</b>
25.	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,987,720,109.39</b>	<b>(1,967,650,463.12)</b>	<b>2,020,069,646.27</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,987,720,109.39	(1,967,650,463.12)	2,020,069,646.27
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,076,791,620.84	-	1,076,791,620.84
9	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>-</b>	<b>(477,213,435.16)</b>	<b>(477,213,435.16)</b>
10	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>5,064,511,730.23</b>	<b>(2,444,863,898.28)</b>	<b>2,619,647,831.95</b>
11	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>5,064,511,730.23</b>	<b>(2,444,863,898.28)</b>	<b>2,619,647,831.95</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(6,520,798.84)	2,156,201.84	(4,364,597.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,057,990,931.39	(2,442,707,696.44)	2,615,283,234.95
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,134,782,830.00	-	1,134,782,830.00
19	Тайлант үеийн үр дүн	-	(141,876,520.92)	(141,876,520.92)
20	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>6,192,773,761.39</b>	<b>(2,584,584,217.36)</b>	<b>3,608,189,544.03</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1.</b>	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-2,904,456.45</b>	<b>(13,748,394.09)</b>
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,240,958,415.59</b>	<b>1,932,119,515.00</b>
1.1.1.	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	151,424,989.00
1.1.3.	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	548,801.00
1.1.5.	Татаас, санхүүжилтийн орлого	1,100,000,000.00	1,756,325,800.00
1.1.6.	Бусад мөнгөн орлого	140,958,415.59	23,819,925.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,243,862,872.04</b>	<b>1,945,867,909.69</b>
1.2.1.	Ажиллагчдад төлсөн	568,709,382.85	817,306,055.81
1.2.2.	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	147,624,539.36	265,853,966.51
1.2.3.	Бараа материал худалдан авахад төлсөн	60,956,416.00	
1.2.4.	Ашиглалтын зардалд төлсөн	16,005,239.36	46,445,186.60
1.2.5.	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	183,036,230.00	441,925,733.36
1.2.7.	Татварын байгууллагад төлсөн	30,803,865.04	91,558,143.16
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	236,727,199.43	282,778,824.25
<b>2.</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>2,702,864.00</b>	<b>14,560,040.00</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>2,702,864.00</b>	<b>14,560,040.00</b>
2.1.5.	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	2,702,864.00	14,560,040.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
2.2.5.	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>4</b>	<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-201,592.45</b>	<b>811,645.91</b>
<b>5</b>	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,221,510.87</b>	<b>1,019,918.42</b>
<b>6</b>	<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>1,019,918.42</b>	<b>1,831,563.73</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	-	-	-	-
2	Нийт орлого	1,756,325,800.00	1,779,259,875.00	22,934,075.00	101.3
	Үүнээс:	1,756,325,800.00	1,779,259,875.00	-22,934,075.00	101.3
	а) Татаас санхүүжилтийн орлого	1,756,325,800.00	1,773,103,800.00	-	-0
	б) Бусад орлого	-	2,182,075.00	-	-
	в) Бусад ашиг (алдагдал)	-	3,974,000.00	-	-
3	Нийт зардал	1,756,325,800.00	1,921,136,395.92	-164,841,595.92	109.3
	Үүнээс:	1,756,325,800.00	1,921,136,395.92	-164,841,595.92	109.3
	а) Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-	-
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	1,756,325,800.00	1,921,136,395.92	-164,841,595.92	109.3
4	Цэвэр ашиг, алдагдал	-	(141,876,520.92)	141,876,520.92	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар **14,425.0** мянган төгрөгийн зөрчил илэрч, 14,425.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 14,425.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 15,988.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй бусад байгууллагад шилжүүлэн ашиглагдаж буй боловч тус байгууллагын дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 14,425.0 мянган төгрөгийн төмөр хашааг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар холбогдох байгууллагад хандсан боловч тодорхой шийдэл гаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана", 67 дугаар зүйлийн 67.2 дахь "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ..." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 3.2 Зөвлөмж

### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 12 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй” гэсэн заалтууд болон болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг дахин үнэлэх болон актлах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>1</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллагын эзэмшилд бүртгэлтэй боловч өөр байгууллагад ашиглагдаж буй хөрөнгийг шилжүүлж, данс бүртгэлээс хасаагүй.	1	14,425.0			1	14,425.0						
Хөрөнгийг дахин үнэлээгүй	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>14,425.0</b>			<b>1</b>	<b>14,425.0</b>	<b>1</b>	<b>-</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>